

ГЛОБАЛ УЛС ТӨРИЙН БОДЛОГЫН ОНОЛ: ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ АЛЬТЕРНАТИВ ӨРНӨЛ ЮУ ВЭ?

Ж.Төртогтох

Профессор, МУИС, Улс төр судлалын тэнхмийн эрхлэгч

Дэлхийн улс төрийн бодлогын тоглогчид, тэдгээрийн харилцааны шинж чанар, онцлог, өнөөгийн глобал улс төрийг тодорхойлдог. Глобал улс төр нь олон улсын улс төр, дэлхийн улс төр, олон улсын харилцаа зэрэг нэр томъёо хэллэгээр танил болсон ч олон улсын харилцааны зөрчил мөргөлдөөнт асуудал, олон улсын эдийн засгийн хүрээнд тавигдаж буй асуудлыг улам бүр өөртөө агуулах болсоноор судалгааны төдийгүй энэ чиглэлийн сургалтын хувьд шинэ шинэ сорилтыг эрдэмтдийн хүрээнд төрүүлсээр байна. Үүнд ч орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны өрнөлийн үйл явц чиглэж байгааг олон улсын улс төр судлаачид анхааралтай ажиглаж, хэлэлцэн дүгнэж, янз бүрийн орны үндэсний шилдэг эрдэмтэн судлаачид тусган авч эрдмийн бүтээлээр идэвхтэй илэрхийлэх болсоныг зайлшгүй анхаарах хэрэгтэй болжээ.

Глобал улс төрийн бодлогын онолын хэтийн төлөв, хандлагань олон улсын улс төрийн харилцаанд голлох тоглогчид хэн болох, глобал улс төрийн харилцааг удирдан чиглүүлэх чухал хүчин зүйлс нь юу болох, олон зууны туршид олон улсын харилцаа хэрхэн өөрчлөгдөж, бас хэвээр хадгалагдан үлдсэн зэрэг үндсэн асуудалд хариулт өгөх нигууртай. Тэдгээр онолын хандлага бүр дээрх асуудалд өөр өөрийн гэсэн онцлогтой хариулт өгөх нь дамжиггүй. Учир нь тэдгээр нь хүн төрөлхтөн, засаг төр, олон улсын улс төрийн бодлогын талаарх өөр өөр таамаглал, нөхцөл байдалд тулгуурласан байдаг. Мөн тэдгээр нь олон улсын улс төр дэх нэгэн ижил үйл явдлын талаар өөр өөр дүн шинжилгээг агуулдаг. Үүнд, Вьетнамын дайн, NAFTA буюу Умард Америкийн Чөлөөт Худалдааны Гэрээ, Дэлхийн Худалдааны Байгууллагын /WTO/ өсөлт ба тэлэлт, Суданы дотоод мөргөлдөөн, АНУ-ын тэргүүлсэн Ирак дахь ажиллагаа зэргийг онцлон авч үзэж болно. Олон улсын улс төрийн бодлогын талаарх эдгээр альтернатив хандлагыг харьцуулан авч үзэж, мэтгэлцэх нь энэхүү өгүүллийн үндсэн зорилго болно. Мөн энэ өгүүлэлдээ зохиогч нь глобал улс төрийн бодлогын онолын хэтийн төлөв, хандлагыг тоймлон авч үзэв. Энэ нь глобал улс төрийн бодлого болон глобал улс төр дэх бүс нутаг, улс орны асуудлын талаарх дутуу дулимаг мэдлэг, өрөөсгөл ойлголтонд тодруулга хийх удирдамж, зөвлөмж болох ач холбогдолтой төдийгүй энэ талаарх судалгааны өргөн хэлэлцүүлэг нээж өгч байгаагаараа давуу талтай болох онцлогтой.

Альтернатив өрнөлийг олон улсын харилцаа, тэр дундаа олон улсын улс төрд хэрхэн авч үзэж байна вэ? Альтернатив онолын хандлагын талаарх ойлголт глобал улс төрийн бодлогыг ойлгоход хоёр шалтгааны улмаас чухал ач холбогдолтой болоод байна.

Нэгдүгээрт, олон улсын харилцаа, бүс нутгийн улс төрийн талаарх аливаа судалгааны чиглэл зарим онолын хандлагыг хэдийнэ хөндсөн байх нь олонтаа. Үүнийг олон улсын харилцааны түүхийн эсхүлорчин үеийн үйл явдлын талаар авч үзэхдээ зайлшгүй тодорхой нэг өнцгөөс ямар нэг факт баримтыг тойрон эргэлдэх хандлагаас ажиглаж болно. Ямар өнцгөөс харж байна, ямар альтернатив хувилбар байж болох вэ гэдгийг мэдэх нь тэдгээр факт баримтыг өөр өөр арга ухаанаар илүү сайн ухаж ойлгож, тайлбарлахад тустай юм.

Хоёрдугаарт, альтернатив онолын хэтийн төлөв, хандлага нь глобал улс төрийн бодлогод дүн шинжилгээ хийх таатай боломжийг судлаачдад олгох учиртай.

Глобал улс төрийн бодлогыг танин мэдэх, бүрэн гүйцэд ойлгоххүлээнзөвшөөрөгдсөнонолынхандлага ньреализм, либерализм, идеализм, нео-марксизм, конструктивизм, феминист хандлагууд юм. Тус бүрдээ олон улсын харилцааг өөр өөр фокуст авч үздэгээрээ ялгагддаг тэдгээр онолын талаар тоймлон авч үзье.

Реализм

Реализм бол олон улсын харилцаа, глобал улс төрийг авч үзэх чухал онолын хандлага. Уг хандлага нь түүхэнд глобал улс төрийн бодлогын талаар улс төрчид болон эрдэмтдийн хувьд хамгийн их авч үзэх дуртай, давамгайлах гэж болох өнцөг нь байж ирсэн. Реализмынталаарханхдагчэхсурвалжнь эртний Грекийн түүхч Фюсидидийз (Thucydides)-ийн бичсэн Грекийн хот-улсууд болох Афин ба Спартагийн хооронд МЭӨ 431-404 онд болсон Пелопонезийн Дайны тухай тэмдэглэл гэж болно. Тэрээр Грекийн тэдгээр хот-улсуудын хоорондын харилцааг реалист байр сууринаас авч үзэж, тодорхойлон тайлбарласан байдаг. 17-20-р зууны эхэн үед ч Европод олон улсын харилцааг ойлгох тэргүүлэх үзэл нь реализм байж ирсэн. Дэлхийн хоёрдугаар дайны дараа олон улсын харилцаа судлаач эрдэмтэд реализмыг глобал улс төрийн бодлогыг тайлбарлах зонхилох хандлага хэмээн хүлээн зөвшөөрсөн. Олон улсын улс төрийн бодлогын реалист онолын энэ үеийн гол төлөөлөгч нь орчин үеийн реалист сэтгэлгээний үндэслэгч Ханс Моргентай (Hans J. Morgenthau) юм. Түүний үзэл санаа дэлхийн хоёрдугаар дайны дараа хэвлэгдсэн “*Politics among Nations: The Struggle for Power and Peace*” хэмээх сонгодог бүтээлд нь тусгалаа олсон юм. Түүний бүтээлийн цар хүрээ, реализмын талаарх зонхилох хандлагаас шалтгаалан глобал улс төрийн талаарх бусад бүх л онолын хандлагууд угтаа реализмын шүүмж эсхүл түүнд үзүүлэх хариу үйлдэл байж ирсэн.

Реализмын нэгэн гол санаа бол Realpolitik буюу глобал улс төрийн бодлогод төр гол тоглогчид байх талаар санаа юм. Төр нь тодорхой нутаг дэвсгэр дээрх бие даасан, бүрэн эрхт, дээд эрх бүхий засаг юм. Бүрэн эрхт байдал нь тэрхүүтөр, тодорхой нутагдэвсгэртхязгааргүйдээдэрхийгхуульёсоорэдлэхбайдалбөгөөдолонулсынсистемдбусадтоглогчтөрийндотоодхэрэгтхөндлөнгөөсоролцоххуульёсныэрхэдлэхгүйболно.

Реалистуудынхувьддэлхийнулстөрдчухамнюуболохыгтодорхойлогчголтөглогчидньтөр улс болохоос тэдгээрийн удирдагчид, иргэд, бизнесийн байгууллага болон олон улсын байгууллага биш юм. Реализмын үзэл нь төр улс бусад тоглогчидоо хянах учиртайг номолсон байдаг.

Реализмын өөр нэгсанаа бол аливаа төрийн үйл ажиллагаа, шийдвэрийн цаад шалтгаан нь тэдгээрийн үнэт зүйлс ч биш, үзэл суртал ч биш, гагцхүүашигсонирхолба түүгээр төрийн хүч чадал, эрх мэдэл, засаглалаар тодорхойлогдоно. Төр улсын ашиг сонирхол нь эрх мэдэл, хүч чадлаа дээд хэмжээнд хүргэн нэмэгдүүлэхэд оршино. Тухайлбал, 1990 онд Кувейтийг дайтсан Иракийн түрэмгийлэл нь реалист хандлагаар үзвэл тэрхүү төрийн эрх мэдэл, хүч чадлын илэрхийлэл болохоос Саддам Хусейны буюу Иракийн удирдагчаас болсон асуудал биш ажээ. Реалист хандлагаар энэ нь ердөө л Иракийн хувьд Кувейтэд хүч чадлаа харуулах улмаар бүс нутгийн бусад улсуудад өөрийн эрх мэдлээ илэрхийлэх боломж байсан бөгөөд Иракийн энэхүү ашиг сонирхол нь тус улс ямар улс төрийн систем, дэглэмтэй байх, ямар удирдагчтай байхаас үл хамааран болох ёстой үйл явдал байсан. Иракийн дээрх түрэмгийллийн эсрэг Кувейтээс Иракийн цэргийг гаргах зорилгоор явуулсан АНУ-ын хариу үйлдэл, шийдвэр нь мөн л өөрийн эрх мэдэл, хүч чадлаа нэмэгдүүлэх гэсэн АНУ-ын ашиг сонирхол байлаа. Учир нь тус бүс нутаг дахь АНУ-ын ашиг сонирхол, эрх мэдэл нь Иракийн дээрх түрэмгийллийн улмаас сулрах эрсдэл байсан тул АНУ-ын удирдсан Цөлийн Шуурга хэмээх цэргийн үйл ажиллагааны цаад шалтгаан нь Кувейтийн ард түмнийг хамгаалах хүмүүнлэгийн сонирхол эсхүл хямд газрын тосоор хангах явдлыг хамгаалах цэвэр эдийн засгийн сонирхлын аль аль нь биш, гагцхүү тус бүс нутагт өөрийн эрх мэдлээ тогтооход л оршиж байсан. Орчин үеийн улс төрийн ухаанд эрх мэдэл, хүч чадал төрийн гол зорилго байх талаарх реалист санааг глобал улс төрд эрх мэдэл-хүч чадлын улс төрийн хандлага хэмээн авч үзэж байна.

Либерализм

Либерализм нь глобал улс төрийн бодлогын мөн чанар, агуулгыг тодорхойлох бас нэг онолын альтернатив хандлага. Глобал улс төрийн бодлогын талаарх онолын хандлагын хувьд үзэж буй либерализмыг дотоод улс төрийн бодлогод “ярьдаг” либерал хэмээх нэр томъёотой адилтган үзэж болохгүй. Учир нь олон улсын салбар дахь улс төр нь илүү нарийн утгатай. Ерөнхийлөн авч үзвэл реализм олон улсын харилцаан дахь чухал замнал, өв, үргэлжлэлийг анхаардаг. Орчин үеийн либерализм нь чухал өөрчлөлт шинэчлэлд анхаарлаа илүү хандуулж байна.

Тухайлбал, либерализмын үүднээс бол 20-р зууны дунд үеэс эхлэн төр ба нийгэм бие биенээсээ улам бүр харилцан хамааралтай болсонтой уялдан хоорондын харилцааны тулгуур арга замыг өөрчлөх болсон. Нэг улсад өрнөсөн үйл явц, өөрчлөлт нөгөө улсад болох өөрчлөлтийг тодорхойлох болсны зэрэгцээ хоёр улсын хоорондын харилцаа, улс орнуудын хоорондын харилцаанд ч нөлөөгөө үзүүлэх болсон.

Либерализмын байр суурьнаас авч үзвэл цогц харилцан хамаарал нь өнөөгийн глобал улс төрийн бодлогын зонхилох шинж болоод байна. Энэ нь юуны өмнө олон улсын улс төрд тоглогчидын дундахь олон янзын сувгуудаар тодорхойлогдож байна. Реализм төрийг цорын ганц чухал тоглогч хэмээн үздэг нь олон улсын улс төрийн бодлого зөвхөн төрөөс төртэй харилцах харилцаагаар хязгаарлагдахад хүргэдэг. Либерализм төр улс хоорондын энэхүү харилцааны ач холбогдлыг үгүйсгэдэггүй боловч глобал улс төрийн бодлогод төр бол цорын ганц чухал тоглогч биш гэж үздэг. Төрөөс гадна олон тоглогч байж болох ба тэдгээр нь дэлхийн улс төрийн тавцанг төртэй “хуваалцан”, зэрэгцэн орших учиртай гэж үздэг. Үндэстэн дамнасан тоглогчид болох глобал түвшинд бизнес эрхэлдэг МакДональдс, КФС, Кока Кола зэрэг Үндэстэн дамнасан корпорациуд нь хил даван үйл ажиллагаа явуулдаг. Эдгээр этгээдүүд нь нэгээс илүү улсад үйлдвэр, аж ахуйн нэгжээ байгуулан, тухайн оронд татвар төлж, хөрөнгө оруулалт хийдэг.

Төрийн бус байгууллага нь үндэстэн дамнасан тоглогчидийн өөр нэгэн хэлбэр юм. Эмнести Интернэйшнл, Улаан Загалмайн нийгэмлэг нь хил дамнасан үйл ажиллагаа явуулдаг, дэлхийн олон оронд гишүүд, төлөөлөл, салбартай олон улсын байгууллага ба үндэстэн дамнасан төрийн бус байгууллагууд болно. Түүнчлэн, НҮБ, Европын Холбоо, НАТО зэрэг Засгийн газар хоорондын байгууллагын гишүүд нь төр улсууд байдаг бөгөөд тэдгээр төр улсуудаасаа тусдаа бие даасан үйл ажиллагаагаа явуулдаг. Либерализмд эдгээр үндэстэн дамнасан корпораци, төрийн бус байгууллага, Засгийн газар хоорондын байгууллага зэргийг төр улсуудын хил дамнасан олон улсын харилцаанд чухал ач холбогдолтой тоглогчид хэмээн авч үзэж байна.

Глобал улс төрийн бодлого дахь цогц харилцан хамаарлын дараагийн утга санаа нь глобал тоглогчидын ашиг сонирхлыг хөндсөн олон асуудал байдагт оршиж байна. Эдийн засаг, үзэл суртал, шашин, соёл, хүрээлэн буй байгаль орчны зэрэг асуудал өнөөгийн глобал асуудлууд болжээ. Тиймээс реализмд онцгойлон авч үздэг аюулгүй байдлын асуудал глобал улс төрийн хамгийн чухал зүйл биш болж байна. Цогц харилцан хамаарлын өөр нэгэн утга санаа нь цэргийн хүч өнгөрсөн үеийнх шигээ үр дүнтэй бөгөөд байнга хэрэглэгддэг зүйл биш болсонд оршино. Төрийн болон төрийн бус тоглогчидийн түвшинд тулгамдсан олон чухал асуудлын шийдэл нь цэрэг дайны шийдэл биш болжээ.

Идеализм

Идеализм нь төр юу хийвэл зохилтой тухай асуудалд төвлөрдөгөөрөө онолын бусад хандлагуудаас ялгаатай юм. Идеализм нь олон талаараа либерализмтай төстэй бөгөөд И.Кантын сургаал зэрэг гүн ухааны үндэс нь ижил тал олон. Либерализмын адилаар дэлхийн улс төрийн бодлого дахь олон улсын байгууллагын үүргийг чухалчилдаг.

Идеалистуудыг зоригжуулсан үнэт зүйлийн нэг бол Дэлхийн хоёр дайны хооронд байгуулагдан ажилласан Үндэстнүүдийн Лиг юм. Тус Үндэстнүүдийн Лиг нь энх тайван ба ардчилал гэсэн үнэт зүйлсийг дэмжин тэтгэхээр байгуулагдсан хэдий ч Дэлхийн хоёрдугаар дайны улмаас бүтээгүй юм. Харин Дэлхийн хоёрдугаар дайны дараа идеалист үнэт зүйлсийг илэрхийлсэн олон улсын аюулгүй байдлын шинэ байгууллага байгуулагдсан нь Нэгдсэн Үндэстний Байгууллага билээ.

Хэдийгээр идеалистууд хүний эрхийг үнэт зүйл болгон чухалчлан авч үздэг ч хүний ямар эрхийг хамгийн чухал бөгөөд универсал хэмээн үзэх талаар өргөн хэмжээний идэвхтэй маргаан байсаар байгаа нь дараах асуултыг зайлшгүй хөндөж байна. Тухайлбал, нэг улс орон, нийгэм өөрийн үнэт зүйлсээ бусдаас дээгүүр тавьж болох, эмэгтэйчүүдийн эрх, угсаатны бүлгүүдийн тэгш эрх, эдийн засгийн тэгш эрх, зандалчлал, боолчлолоос ангид байх эрх чөлөө, цаазаар авах ялаас ангид байх эрх чөлөө, ардчилсан улс төрийн эрх зэргийг дээдэлдэг улс орон тийм биш улс орнуудад үүнийгээ тулгаж болох, хүний эрхийг хамгаалах, хангахын тулд цэргийн хүч хэрэглэх асуудлаар идеалистууд санал зөрөлдөөнтэй байна.

Нео-марксизм

Нео-Марксизм нь төрд төвлөрсөн реалист хандлагыг үндсээр нь хүлээн зөвшөөрдөггүй. Реализм анархи олон улсын систем, эрх хүчний төлөөх төрийн тэмцэл, өрсөлдөөнийг авч үздэг бол нео-марксист хандлага нь капитализмын олон улсын систем, эдийн засгийн ангийн дундах өрсөлдөөн, улс төр ба нийгмийн харилцааг голчлон авч үздэг.

Онолын энэ хандлагын үүднээс авч үзвэл, эдийн засаг нь глобал улс төрийн бодлогын үндэс нь болно. Энэ үүднээсээ нео-марксизм нь Марксист чиг хандлагатай юм. Гэвч Маркс улс орнуудын дотоод дахь ангийн зөрчилд төвлөрч байсан бол нео-марксистууд глобал ангийн зөрчилд голлон анхаарч байна.

Олонх нео-марксистууд глобал улс төрийн бодлогыг түүхэн хандлагаар авч үзэн, дэлхий дахины эдийн засгийн системийн хөгжилд анхаарлаа хандуулж байна. Энэхүү хандлагаар бол дэлхийн эдийн засгийг голлох ба туслах гэсэн хоёр талбарт хуваан үзэж байна. Голлох эдийн засаг буюу ихэнх хөгжингүй орнуудын эдийн засгаар баялгийн төвлөрлийг авч үздэг бол туслах буюу хөгжиж буй орнуудын эдийн засгийн онцлог нь баялагийн хуримтлал ба төвлөрөл хараахан хөгжөөгүйд оршиж байна.

Нео-марксизм нь глобал улс төрийн бодлогын альтернатив үзэл болохын хувьд эдийн засагт голлон төвлөрч байгаагаараа цэргийн эрх хүчинд ач холбогдол өгөгч реалист үзлийн зэрэгцээ өөр өнгө төрх болж байна. Түүнчлэн, либерализм харилцан хамаарлыг төр улсуудын хоорондох болон төрийн бус оролцогчдын хоорондох хамтын ажиллагааны асуудлыг голчилж байхад нео-Марксист хандлага нь харилцан хамаарлын тодорхой хэв маяг болох голлох эдийн засгуудаас хамааралтай туслах эдийн засгуудын хамаарлыг глобал эдийн засгийн ангиудын дундах гол зөрчил мөргөлдөөн байх болно хэмээн тайлбарлаж байгаа юм.

Дүгнэлт

Глобал улс төрийн бодлогын онолууд нь олон улсын улс төрд хэн нь гол тоглогч вэ, олон улсын улс төрд тэдгээр тоглогчид чухам юуг яагаад хийдэг вэ, олон улсын улс төр дэх хамтын ажиллагаа ба зөрчил мөргөлдөөний мөн чанар нь юу вэ зэрэг асуултуудад хариулт эрэлхийлэхэд чиглэгдэж байна.

Реализм онолын зонхилох хандлага байсаар ирлээ. Учир нь глобал улс төрд тусгаар улс орнуудын гүйцэтгэх үүрэг өндөр хэвээр байна. Либерализм олон улсын системийг төрийн зэрэгцээх тоглогчдоор өргөжүүлэхийг дэмжин тэдгээрт өндөр ач холбогдол өгсөөр байна. Төр улсуудын хоорондох болон төрийн бус оролцогчдын олон төрөл харилцаа холбоо нь эдийн засгийн сонирхол, улс төрийн эрх ашгийн алинд ч илрэх болжээ. Идеализм нь төр улсууд нь глобал улс төрд өөрсдийн үнэт зүйлээ даган эрхэмлэхийг сургасаар, гадаад бодлого ба олон улсын байгууллагууд энх тайван, хүний эрхийг хамгаалахад чиглэх учиртайг сануулсаар байна.